



**МОНГОЛ УЛС**  
**УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА**

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165  
Утас: 7045-2315, Факс: 7045-4095  
Цахим шуудан: info@uvs.gov.mn  
Цахим хуудас: www.uvs.gov.mn

2023.03.14 № 2/447

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН**  
**ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН**  
**АЖЛЫН АЛБАНД**

Танай 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 2/07 тоот албан бичгийг хүлээн авч танилцлаа.

Увс аймгийн Дэд зөвлөлийн 2023 оны ажлын нэгдсэн тайланг гарган хүргэж байна.

Хавсралт 12 хуудастай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



ЖАЛЕКСАНДР

**8524020382**

D disk: AZDTG- zasag A-5

**Дэд зөвлөлийн дарга:**

Увс аймгийн Засаг даргын орлогч,  
Л.Ж.Александр!

Увс аймгийн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

Хэрэгжүүлэх арга хэмжээ  
Зорилт 1. Судалгаа, тайлан мэдээ гаргах, сургалт зохион байгуулах  
Үр дүн  
Хугацаа  
Төсөв  
Хариуцагч

1	Дэд зөвлөлийн хурал зохион байгуулах	Дэд зөвлөлийн чадавх бэхжих /ЗУДАА/	1-4	Дэд зөвлөлийн нарийн бичиг, БОАЖГ
2	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжийн тайланг сонсох, сүмдын гаргах, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах	Бодит судалгаагаар болно	2-4	АЗДТГ, БОАЖГ, ГХБХБГ, МХГ, ЦГ
3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд "Увс аймагт хэрэгжих Хоёр живаа харгаа хөтөлбөр"-т үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжийг татан оролцуулах	Байгаль орчны тэнцвэрт байдал бий болно	2-3	АЗДТГ, БОАЖГ, СЗДТГ
4	Хууль тогтоомжийн дагуу холбогдох тайлан мэдээг гаргах	ОУИТБ хангагдана	2, 4	АЗДТГ, БОАЖГ, СЗДТГ
Зорилт 2. Иргэдэд нээлтэй ил тод байдлыг таниулах, хяналт шалгалтыг зохион байгуулах				
5	Аймгийн хэмжээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, зөвлөн туслах	ОУИТБ хангагдана	2-4	АЗДТГ, БОАЖГ, ГХБХБГ, МХГ, ЦГ, АИТХ-ын ДЭРГЭДЭХ ХБӨЭГХУУССЗ /хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл/
6	Шинээр байгуулагдсан гэрээнүүдийг www.ilrodoregee.mn сайтад байршуулах	Мэдээллийн ил тод байдал хангагдана	3-4	АЗДТГ

Улиралд

Аймгийн олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга: .....Л.Төвсанаа

Улиралд


Увс аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн  
2023 оны үйл ажиллагааны тайлан

**Зорилт 1. Судалгаа, тайлан мэдээ гаргах, сургалт зохион байгуулах.**

**1.1 Дэд зөвлөлийн хурал зохион байгуулах**


Увс аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөл 2023 оны 06 дугаар сар, 09 дүгээр саруудад аймгийн хэмжээнд хураалдаан хийв. Тус хуралд 19 сумын удирдлагууд болон аймгийн байгаль орчны хяналтын байгууллагууд оролцов.






2023 оны 10 дугаар сарын 10-нд ОУИТБС-ын дэд зөвлөлийн нийт гишүүдийг чадваржуулах сургалтыг зохион байгуулав. Тухайн сургалтад аймгийн 19 сумын Засаг дарга болон байгаль орчны байцаагч мэргэжилтэнүүд хамрагдав.





Чадвахжуулах сургалт зөвлөгөөн Уул уурхай хүнд үйлдвэрлэлийн яам, ашигт малтмал газрын тосны газар, монголын уул уурхайн үндэсний ассоциациас Говь алтай аймагт зохион байгуулсан "Хариуцлагатай Уул уурхай" өдөрлөгт Увс аймгаас 13 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.



Мөн Монгол улсын хэмжээнд Уул уурхайн яамнаас зохион байгуулсан Mining Week 2023 (Уул уурхайн долоо хоног 2023) нэгдсэн арга хэмжээнд Увс аймгийн удирдлагууд холбогдох мэргэжилтнүүд оролцсон.



**Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд:** "Увс аймагт хэрэгжих Хоёр живаа харгаа хөтөлбөр"-т үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжийг татан оролцуулах

Монгол улсын Ерөнийлөгчийн 58 дугаар зарлигийн хүрээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг улс орон даяар зохион байгуулагдан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулж, тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 9 аж ахуйн нэгжид БОАЖГ-тай хамтран албан бичиг хүргүүллээ.

1. Хотгор ХХК өөрийн уурхай дээрээ 600ш бургас мод тарьсан
2. Ник ХХК Улаангом сумын Ногоон төгөл цэцэрлэгт 30ш монос мод
3. Чандмань Уулын хишиг ХХК Өөрийн Үйлдвэрийн хажууд 40ш Улиас мод
4. Эй эл жи ти Харганатын хүдэр ХХК Наранбулаг суманд 1км Газрыг хашаажуулж 2024 онд сум нь өөрсдөө мод тарихаар бэлтгэж байна.
5. Магнай Трейд ХХК Улаангом суманд ШТС 67 хажууд 30ш улиас тарьсан байна.

**Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах:**

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 7 ААН-тэй 2023 оны 1 дүгээр улиралд хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан. Дээрх аж ахуй нэгжүүдээс БОАЖЯ-ны БОМТ-ний цахим мэдээллийн санд Хотгор ХХК, Чандмань Уулын Хишиг ХХК, Жамц давс ХХК, Эй Эл Жи Ти ХХК, зэрэг аж ахуйн нэгжүүд байгаль орчныг

хамгаалах менежмент төлөвлөгөөгөө байршуулсан. Мөн Түгээмэл тархацтай ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Тоосгон уул ХХК, Нэтэнт ХХК, Энержи Импайр ХХК-ны байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тодотгол хийгдэж дууссан ба БОНБНУ-ний тайланг ирүүлснээр үйл ажиллагаа энэ онд явуулсан.

- 2023 оны 11 дүгээр сарын байдлаар Уул Уурхайн ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Эй эл жи ти" ХХК, "Чандмань уулын Хишиг" ХХК, "Энержи импайр" ХХК, "Нэтэнт" ХХК, "Тоосгон уул" ХХК, "Хар Тарвагатай" ХХК, "Хотгор" ХХК, "Эрчим баян Өлгий" ХХК зэрэг 8 компани үйл ажиллагаа явуулж байна. Дээрх аж ахуй нэгжүүд өөрсдийн олборлолт дууссан талбайг нөхөн сэргээхээс гадна дүйцүүлэн хамгаалалтаар болон нийгмийн хариуцлагын хүрээнд "Тоосгон Уул" ХХК Түргэн сумын нутагт 6га, "Хотгор" ХХК Бөхмөрөн сумын Хар алтад багийн Улаан эрэгт 0.7 га талбайг дүйцүүлэн хамгаалалтаар, Тариалан сумын Бор хавцалд Бичил уурхайчид 3.57 га, Улаангом сумын 1 дүгээр багт "Нэтэнт" ХХК 1га, "Хотгор" ХХК тусгай зөвшөөрөлтэй MV-014442 талбайд 0.33га, MV-014441 талбайд 0.46 га, нийт 0.79 га талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийсэн. 2023 онд нийтдээ 12,06 га талбайд нөхөн сэргээлтийн ажил хийгдлээ.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч 5 компанийн уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн мэдээг <https://www.eic.mn/> мэдээллийн санд шивж орууллаа.

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдээс, нүүрсний ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Хартавагатай", "Хотгор", "Эрчим уурхай", Төмрийн хүдрийн "Эй Эл Жи Ти" мөн ТТАМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Чандмань Уулын хишиг", "Нэтэнт", "Энержи Импайр", зэрэг аж ахуй нэгжүүд Тариалан, Бөхмөрөн, Улаангом, Наранбулаг сумын ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд байгуулсан.

Дээрх аж ахуй нэгжийн 4 төрлийн /нийт 20 гэрээг [iltodgeree.mn](http://iltodgeree.mn) мэдээллийн нэгдсэн цахим санд байршуулсан.

## **Зорилт 2. Иргэдэд нээлттэй ил тод байдлыг таниулах, хяналт шалгалтыг зохион байгуулах**

2.1 Аймгийн хэмжээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, зөвлөн туслах.

2023 онд Монгол улсын Засгийн газрын 2023 оны 79 тоот тогтоолоор "Хяналт шалгалтын төлөвлөгөө" батлагдсан. Нэгдсэн төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын ХБТХОХ-ийн хяналтын улсын байцаагчид 6 хяналтын чиглэлээр 53 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэхээс 47 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийсэн. Тайлант онд төлөвлөгдсөн 5 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаагүй тул хяналт шалгалтад хамрагдаагүй болно. Холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, нормын хэрэгжилтийг хангуулан илэрсэн зөрчил дутагдлыг

хамгаалах менежмент төлөвлөгөөгөө байршуулсан. Мөн Түгээмэл тархацтай ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Тоосгон уул ХХК, Нэтэнт ХХК, Энержи Импайр ХХК-ны байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тодотгол хийгдэж дууссан ба БОНБНУ-ний тайланг ирүүлснээр үйл ажиллагаа энэ онд явуулсан.

- 2023 оны 11 дүгээр сарын байдлаар Уул Уурхайн ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Эй эл жи ти" ХХК, "Чандмань уулын Хишиг" ХХК, "Энержи импайр" ХХК, "Нэтэнт" ХХК, "Тоосгон уул" ХХК, "Хар Тарвагатай" ХХК, "Хотгор" ХХК, "Эрчим баян Өлгий" ХХК зэрэг 8 компани үйл ажиллагаа явуулж байна. Дээрх аж ахуй нэгжүүд өөрсдийн олборлолт дууссан талбайг нөхөн сэргээхээс гадна дүйцүүлэн хамгаалалтаар болон нийгмийн хариуцлагын хүрээнд "Тоосгон Уул" ХХК Түргэн сумын нутагт 6га, "Хотгор" ХХК Бөхмөрөн сумын Хар алтад багийн Улаан эрэгт 0.7 га талбайг дүйцүүлэн хамгаалалтаар, Тариалан сумын Бор хавцалд Бичил уурхайчид 3.57 га, Улаангом сумын 1 дүгээр багт "Нэтэнт" ХХК 1га, "Хотгор" ХХК тусгай зөвшөөрөлтэй MV-014442 талбайд 0.33га, MV-014441 талбайд 0.46 га, нийт 0.79 га талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийсэн. 2023 онд нийтдээ 12,06 га талбайд нөхөн сэргээлтийн ажил хийгдлээ.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч 5 компанийн уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн мэдээг <https://www.eic.mn/> мэдээллийн санд шивж орууллаа.

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдээс, нүүрсний ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Хартавагатай", "Хотгор", "Эрчим уурхай", Төмрийн хүдрийн "Эй Эл Жи Ти" мөн ТТАМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Чандмань Уулын хишиг", "Нэтэнт", "Энержи Импайр", зэрэг аж ахуй нэгжүүд Тариалан, Бөхмөрөн, Улаангом, Наранбулаг сумын ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд байгуулсан.

Дээрх аж ахуй нэгжийн 4 төрлийн /нийт 20 гэрээг [iltodgeree.mn](http://iltodgeree.mn) мэдээллийн нэгдсэн цахим санд байршуулсан.

## **Зорилт 2. Иргэдэд нээлттэй ил тод байдлыг таниулах, хяналт шалгалтыг зохион байгуулах**

2.1 Аймгийн хэмжээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, зөвлөн туслах.

2023 онд Монгол улсын Засгийн газрын 2023 оны 79 тоот тогтоолоор "Хяналт шалгалтын төлөвлөгөө" батлагдсан. Нэгдсэн төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын ХБТХОХ-ийн хяналтын улсын байцаагчид 6 хяналтын чиглэлээр 53 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэхээс 47 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийсэн. Тайлант онд төлөвлөгдсөн 5 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаагүй тул хяналт шалгалтад хамрагдаагүй болно. Холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, нормын хэрэгжилтийг хангуулан илэрсэн зөрчил дутагдлыг




арилгуулахаар улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлэн ажиллаж байна. Тайлант онд нийтдээ албан шаардлага 26, зөвлөмж 11, дүгнэлт 5 тус тус гаргасан байна. Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 1 аж ахуйн нэгжид захиргааны арга хэмжээг ноогдуулсан.

Богдмөрөн сумын Хотгор ХХК-ийн уурхайд



Давст сум Жамц Давс ХХК талбайд



Давст сумын Давс-Эрдэнэ нөхөрлөлийн талбайд






Эрчим ХХК-ийн Уурхай



Тариалан сумын Хартарвагатай ХХК-ийн уурхайд



Тариалан сумын нутагт байрлах Хартарвагатай ХХК Алтны уурхайд



Аймгийн хэмжээнд хяналт шалгалт хийсэн ОУИТБС-ийн дэд зөвлөлийн бүрэлдэхүүн



Тайлан гаргасан:  
ОУИТБС-ын Увс аймгийн дэд зөвлөлийн

Нарийн бичгийн дарга ..... / Т.Төвсанаа /